# Увс аймгийн БТСГ-ын ХШҮ-ний тайлан

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

### УВС АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР 2025 ОН

| Хамаарах зорилт | Үр дүн | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Зорилтот түвшин | | | | Шалгуур үзүүлэлтийн тайлбар | Мэдээлэл цуглуулах давтамж | Хариуцах байгууллага | | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2025 | 2026 | 2027 | 2028 | | | Үндсэн | Хамтран | |
| Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн | | | | | | | | | | | | | |
| НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | | | | | | |
| 2.1.4.1<br>2.1.4.4 | Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшинг нэмэгдүүлсэн байна. | Хүн амын бие бялдарын хөгжлийн индекс, хувиар | Хувь | 76.2 (67.7) | 76.2 (68) | 77 (69) | 78 (70) | 79 (71) | Сорилд хамрагдан A,B,C үнэлгээтэй хүний тоог сорилд хамрагдсан хүний тоонд харьцуулж 100-гаар үржүүлнэ. | Жил тутам | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам | БТБХХ | Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, нэгтгэх, цахим программд оруулах ажил хийгдэж байна. Аймгийн хэмжээнд 4500 гаруй иргэдийг сорилд хамруулсан. Одоогоор цахим программд 2800 иргэний мэдээлэл шивэгдэж орсон байна. |
| | | Монголын Хүүхдийн спортын өвлийн 8 дугаар их наадам | | | | | | | | | | | Хүүхдийн спортын 8 дугаар наадмын өвлийн төрлийн анхан шатны тэмцээнийг гүйлтийн цаны төрөлд зохион байгуулж 70 гаруй өсвөрийн тамирчид оролцсон. Шигшээ тэмцээнд 2 дасгалжуулагч, 14 тамирчин оролцож 3 алт, 5 мөнгө, 7 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 1-р байрт шалгарсан. Тамирчдын зардалд улсын төсвөөс 3.1 сая төгрөгийг зарцуулсан. |
| | | Монголын Хүүхдийн спортын зуны 8 дугаар их наадам | Тоо | | | | | | | | | | Хүүхдийн спортын зуны 8 дугаар наадмын анхан шатны тэмцээнийг спортын 15 төрлөөр зохион байгуулж, давхардсан тоогоор 3100 гаруй тамирчид хамрагдсан. Шигшээ тэмцээнд спортын 15 төрөлд 145 тамирчин оролцож 4 мөнгө, 7 хүрэл медаль нийт 11 медаль хүртсэн. Тамирчдын зардалд спортыг дэмжих төсөл, арга хэмжээний зардлаас 52.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Монголын бүх ард түмний спортын 16 дугаар их наадам | | | | | | | | | | | Монголын бүх ард түмний спортын 16 дугаар их наадмын анхан шатны тэмцээнийг спортын 8 төрлөөр зохион байгуулж, 1500 гаруй иргэд хамрагдсан. Шигшээ тэмцээнд спортын 14 төрлөөр 105 тамирчин оролцож 1 алт, 5 мөнгө, 7 хүрэл нийт 13 медаль хүртсэн. Тэмцээний зардалд спортыг дэмжих төсөл, арга хэмжээний зардлаас 36.8 сая төгрөгийг санхүүжүүлсэн. |
| | | Монголын бүх ард түмний спортын зуны наадам, ХБИ-ийн спортын төрлүүд | Эрэмбэ | | | | | | | | | | Бүх ард түмний спортын их наадмын ХБИ-ийн спортын наадамд хонхот бөмбөг, пара жүдо бөх, диф волейбол, пара хөнгөн атлетик төрөлд 30 тамирчин оролцож 2 алт, 1 мөнгө, 4 хүрэл медаль хүртсэн. Багийн дүнгээр 6-р байрт шалгарсан. |
| **Хөтөлбөрийн үр дүн** | | | | | | | | | | | | | |
| **НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | | | |
| 2.1.4.1<br>2.1.4.2 | Биеийн тамир, спортын орчны хүртээмжийг сайжруулсан байна. | Спортын барилга байгууламжаас 15 минутын зайд амьдарч буй хүн ам | Хувь | - | 1 | - | - | 3 | "Спортын барилга байгууламжаас 15 минутын хугацаанд явган алхаж очих (алхах хурд 4 км.цаг) зайд амьдарч буй хүн амын хувь"-аар тооцно. | 3 жил тутам | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам | БТБХХ | Аймгийн төв, сумын төвд спортын барилга байгууламжаас 150 минутын зайд байрлах хүн амын тоо 64.0 байна. Хүүхэд залуучуудын спортоор хичээллэх орчин бүрдүүлэх зорилгын хүрээнд спорт заал 1, 3х3, 5х5 сагсан бөмбөгийн талбай тус бүр 1, иргэдийн биеийн тамираар хичээллэх боломжтой биеийн тамрын талбай 3-аар нэмэгдсэн байна.<br>**Хэрэгжилт:100%** |
| 2.1.4.2<br>2.1.4.3 | Өрсөлдөх чадвартай тамирчдын нөөцийг нэмэгдүүлсэн байна. | Норматив хангаж буй тамирчид | Хувь | | 5 | | | | | | | | Өсвөрийн шигшээ багийг бүрдүүлэх, санхүүжүүлэх журам батлах тухай тухай Аймгийн засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/549 тоот захирамж гарч өсвөрийн шигшээ багийг спортын 5 төрөлд , үүнээс багийн спортын 3 төрөл, бөхийн спортын 2 төрлөөр тус тус байгуулахаар шийдвэрлэсэн |
| | Олимп, паралимпын | Залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс авсан медаль | Тоо | | 3 | | | | | | | | Мөсөнд авиралтын залуучуудын ДАШТ-алт, хүрэл, халз тулааны ДАШТ-ээс хүрэл медаль хүртсэн. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.4.2 | спортын төрлөөр өсвөр үе, залуучуудын амжилтыг ахиулсан байна. | Өсвөрийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс авсан медаль | Тоо | | 1 | | | | | | | | 100 буудалт даамын өсвөр үеийн ДАШТ-с ЕБ-ийн 3 дугаар сургуулийн сурагч Б.Сансармаа алтан медаль хүртсэн. |
| | | Улсын аварга шалгаруулах тэмцээнээс авсан медаль | Тоо | | 147 | | | | | | | | Өсвөр болон насанд хүрэгчдийн ангилалд УАШТ-с нийт 147 медаль хүртсэн байна. |
| 2.1.4.2<br>2.1.4.4 | Хүн амын идэвхтэй хөдөлгөөн, спортын мэдлэг, хандлага, дадлыг нэмэгдүүлсэн байна. | Мэдлэгийн өөрчлөлт | Хувь | 67 | 67 | 68 | 68 | 69 | Зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан оролцогчдын асуулгын дундаж үнэлгээ | Жил тутам | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам | БТБХХ | Иргэдийн эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих зорилтын хүрээнд<br>- Өглөөний алхалт, гүйлт 4501<br>- Ажлын байрны Түмэн дасгал 6000<br>- Өвлийн арга хэмжээг 7 суманд 9 удаагийн арга хэмжээнд 4641<br>- Өсвөр үеийнхэний 5 арга хэмжээ 1156<br>- Үндэсний спортын 60 арга хэмжээ 7393<br>- Ахмадын биеийн тамирын чиглэлээр 14 арга хэмжээ 793<br>- Дасгал хөдөлгөөний ач холбогдол сэдвээр 11 байгууллага, 8 сумын албан хаагчдад мэдээлэл хүргэж, Танита аппаратаар 900 гаруй иргэдэд зөвлөмж өгч ажилласан.<br>Нийт 2 аян, 88 арга хэмжээ, сургалт мэдээллийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 25384 иргэн хамрагдсан байна.<br>**Хэрэгжилт: 100 %** |
| | | Хандлагын өөрчлөлт | Хувь | 69 | 70 | 70 | 70 | 70 | Зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан оролцогчдын асуулгын дундаж үнэлгээ | Жил тутам | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам | БТБХХ | |
| | | Дадлын өөрчлөлт | Хувь | 37 | 37 | 37 | 37 | 37 | Зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан оролцогчдын асуулгын дундаж үнэлгээ | Жил тутам | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам | БТБХХ | |

Тайланг хянасан БТСГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Бадарч

Биелэлт гаргасан: БТХ-ийн дарга Х.Баяртуул

9065334 1524056002

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | эрхэлсэн агентлаг, театр, музей, номын сан, дүүргийн соёлын ордны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг зөвшилцсөний үндсэн дээр Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаар гүйцэтгүүлэн, тайлан мэдээг соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын асуудал эрхэлсэн яаманд хүргүүлж, үр дүнг тооцож ажиллана. | | | | хяналт шалгалтыг тус тус хийсэн.<br><br>ССАЖЗЯ-ны хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас төлөвлөгөөт хяналт, шалгалтыг 1 удаа хийсэн.<br><br>Төрийн аудитын хяналт шалгалтаар 1 зөвлөмж, аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын газраас 4 зөвлөмж авч зөвлөмжийн биелэлтийг хугацаанд нь гаргаж шилэн дансанд ил тод мэдээлсэн байна.<br>Хэрэгжилт-100% |
| 8 | 4.14 Гэрээний хавсралтад заасан арга хэмжээ, шалгуур, үзүүлэлт үр дүнг Сайдын өмнө хариуцан тайлагнах; | - | | Хагас бүтэн жилээр тайлагнасан байна. | Гэрээний хавсралтад заасан арга хэмжээ, шалгуур, үзүүлэлт үр дүнг хагас, бүтэн жилээр тайлагнасан. |

| | |
|---|---|
| Хэрэгжилтийн дундаж хувь | 98,6 хувь |

Тайланг хянасан: Увс аймгийн БТСГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч ......................Б.Бадарч

Тайланг боловсруулсан: Увс аймгийн БТСГ-ын БТХ-ийн дарга, Тогтоол шийдвэрийн биелэлт, тайлан мэдээ, хүний нөөц хариуцсан ажилтаны албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ......................Х.Баяртуул

УВС АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

## Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

2025 ОН

2025 оны 11 сарын 24

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| МУЕЗарлиг | | | | | | | |
| 1 | 1 | Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай<br>3/26/2010<br>дугаар 53 | 1.Монгол Улсын хүн амын орчин үеийн эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургах, аливаа саад, бэрхшээлийг даван туулах бие, сэтгэлийн тэсвэр хатуужилтай шинэ үеийг бий болгох зорилгоор "Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-ыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар жил бүрийн дөрөвдүгээр сард явуулж, үнэлэлт, дүгнэлтийг үндэслэн шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай. | "Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, нэгтгэх, цахим программд оруулах ажил хийгдэж байна. Аймгийн хэмжээнд 4500 гаруй иргэдийг сорилд хамруулсан. Одоогоор цахим программд 2800 иргэний мэдээлэл шивэгдэж орсон байна. | 62.2 | | |
| | | | 2.Биеийн тамир, спортыг нийтийн үйл хэрэг болгох зорилгоор дунд болон их, дээд сургуулиудад биеийн тамир, спортыг сургалтын тэргүүлэх чиглэл болгож, сурагч, оюутнуудыг спортоор хичээллэх таатай орчин нөхцлөөр хангах, спортын хамтлаг, клубын тогтолцоог нэвтрүүлж ажиллахыг төрийн болон төрийн бус байгууллага, тамирчид, багш дасгалжуулагчид, бизнесийн бүх байгууллага, нийт ард иргэдэд уриалсугай. | Аймгийн хэмжээнд биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Спортын клуб, хувь хүмүүстэй хамтран ажиллаж байна. 2025 онд волейболын төрлөөр 4 клуб, бөхийн төрлөөр 22 дэвжээ, цанын 4 клуб, шатрын 2 клуб, 100 буудалт даамын 2, ширээний теннисний төрлөөр 1 клуб, таеквондогийн төрөлд 1 клуб, Фитнес клуб 1, иогийн клуб 1, бусад спортын сонгон секцэд 4800 гаруй өсвөр, залуучууд хамрагдан хичээллэж байна. Нөөц боломжид тулгуурлан спортын хэрэглэл материал, байраар хангаж ажиллаж байна. Ерөнхий Боловсролын сургуулийн 10,11,12 дугаар ангийн сурагчдын дунд "Спортлог анги", " Нэг анги Нэг баг" арга хэмжээг тогтмол зохион байгуулж хэвшүүлсэн. | 100% | | |
| ЗГ-ын тогтоол | | | | | | | |
| | | Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай<br>8/30/2023 | 2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх | Ажлын байрны "Түмэн дасгал", "Алхахад цаг гаргая"- 2 сарын аяныг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн дунд зохион байгуулж , аяны хүрээнд Улаан уул, Гашууны голын чиглэлд алхаж буй иргэдийг сурталчлах, 10.000 алхалтыг хэмжигч "Strava application" татаж цахим уралдаан оролцох талаар мэдээлэл сургалт сурталчилгаа, алхалтад уриалсан нөлөөллийн арга хэмжээг байгууллагын цахим хуудсаар болон бусад мэдээллийн хэрэгслээр сурталчлах, идэвхжүүлэх ажлыг тасралтгүй зохион байгуулсан. Аянд оролцогчид "Өглөөний дасгал, алхалт, гүйлтийг хэвшүүлье" цахим группд өдөр тутам алхалт, ажлын байрны дасгалын зураг бичлэгээ оруулан, оролцож байгаа байгууллага | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | Дугаар 2023_321 | арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай. | сум, иргэдийг бүртгэлийг хийж, дүгнэх ажлыг явуулж, аяны хүрээнд алхалтын арга хэмжээнд 12 сумын давхардсан тоогоор 4.250 хүн, ажлын байрны дасгалын арга хэмжээнд 75 байгууллагын давхардсан тоогоор 6.000 гаруй хүнийг хамруулсан байна.Ажлын байрны "Түмэн дасгал"-ын арга хэмжээнд эхний 3 байрыг Төв номын сан, 5-р сургууль, Дулааны 2 станц, сумуудаас Сагил ЭМТ, Зүүнговь сумын хийлийн цэргийн 328-р анги, Өндөрхангай сумын ЭМТ эзэлсэн байна. Алхалтын арга хэмжээнд сумуудаас Наранбулаг, Тэс, Бөхмөрөн, байгууллагуудаас Музей, БОГ, УЦУОШГ тус тус эхний байруудыг эзэлж, мөнгөн шагналаар шагнагдсан. Үүнээс гадна "Дасгал хөдөлгөөний ач холбогдол" сэдвээр 11 байгууллага 8 сумын албан хаагчдад сургалт явуулж, Танита аппаратаар халдварт бус өвчний эрсдэлийг тодорхойлж, зөвлөмжийг 900 гаруй хүнд хүргэж, 0-5 настай хүүхэдтэй эхчүүдэд "Бага насны хүүхдийн хоол тэжээл","Дасгал хөдөлгөөний ач холбогдол"- сэдвээр 4 удаагийн сургалтанд 45 ээжийг хамруулсан байна бөгөөд нийт 2 аян, сургалт, мэдээлэл нөлөөллийн арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 17.905 хүн хамрагдсан байна. | 100% | | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | |
| 2 | 2 | 2022 оны 11 дүгээр сарын 9- 11/9/2022 Дугаар 2022_54 | III.2. Иргэдэд хоол, хүнсний илчлэг (калори)-ийн талаар ойлголтыг олгож зохистой хэрэглээг бий болгох, эртэч, бүтээлч, зөрөг, зөв хандлагатай эрүүл амьдралын хэмнэлийг бий болгох зорилгоор үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэх талаар хамтран шуурхай ажиллаж, дүнг танилцуулахыг Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Соёлын сайд Ч.Номин, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт даалгав. | Монголын шугаман бүжгийн холбоотой хамтран ШУГАМАН БҮЖИГ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДАСГАЛ ХӨДӨЛГӨӨН-ний сургалтыг Насан туршийн боловсролын төвд зохион байгууллаа. Энэхүү сургалтад 50 гаруй иргэд хамрагдаж өглөө бүр дасгал хийсэн.Аймгийн ЭМГ-тай хамтран Ажлын байрны "Түмэн дасгал, "Алхахад цаг гаргая" 2 сарын аяныг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн дунд зохион байгуулж аяны хүрээнд Улаан Уул, Гашууны голын чиглэлд алхаж буй иргэдийг суталчлах, 10000 алхалтыг хэмжигч " Strava" апп-ийг татаж цахим уралдаанд оролцох талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа, алхалтад уриалсан нөлөөллийн арга хэмжээг БТСГ-ын цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр сурталчлах, идэвхжүүлэх, ажлыг тасралтгүй зохион байгуулсан. | 100% | | |
| 3 | 3 | 2023 оны 11 дүгээр сарын 11/8/2023 Дугаар 2023_45 | XI.1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг судалж, төлөвлөсөн хугацаа, үр дүнг тооцож, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав; | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3,4 дүгээр улирал тусгагдсан 3 арга хэмжээ санхүүжилт байхгүйн улмаас хэрэгжээгүй байна. | 80% | | |
| ЗГ-ын албан даалгавар | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 8 | Дугаар 2024_01_1 | 19.7. 19.7. Энэ албан даалгаврын 1.12-т заасан реформыг хэрэгжүүлэх хүрээнд биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг нэмэгдүүлэх, эрүүл амьдралын дадал хэвшлийг дэмжих чиглэлээр олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжүүлэх. | Иргэдийн эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих зорилтын хүрээнд - Өглөөний алхалт, гүйлт 4501<br>- Ажлын байрны Түмэн дасгал 6000<br>- Өвлийн арга хэмжээг 7 суманд 9 удаагийн арга хэмжээнд 4641<br>- Өсвөр үеийнхэний 5 арга хэмжээ 1156<br>- Үндэсний спортын 60 арга хэмжээ 7393<br>- Ахмадын биеийн тамирын чиглэлээр 14 арга хэмжээ 793<br>- "Дасгал хөдөлгөөний ач холбогдол" сэдвээр 11 байгууллага, 8 сумын албан хаагчдад мэдээлэл хүргэж, Танита аппаратаар 900 гаруй иргэдэд зөвлөмж өгч ажилласан.<br>Нийт 2 аян, 88 арга хэмжээ, сургалт мэдээллийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 25384 иргэн хамрагдсан байна.<br>Хэрэгжилт: 100 % | 100% | | |

0

Тайланг хянасан БТСГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Бадарч

Биелэлт гаргасан: БТХ-ийн дарга Х.Баяртуул

**АЛСЫН ХАРАА – 2050**
**УВС АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР**
**2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС**

2025 оны 11 дүгээр сарын 19 -ны өдөр

| № | Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар) | Гүйцэтгэл хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Он | Суурь түвшин | | | |
| ЗОРИЛГО 1. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ | | | | | | | | |
| 1 | Зорилт 1.5. Дэлхий дахинд монгол үндэсний үнэт зүйлсийн дархлаа тогтож, монгол соёлыг түгээн дэлгэрүүлж, Монгол Улсын нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлж, хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатны хамтын ажиллагаа төлөвшинө. | | | | | | | |
| 1.1 | Арга хэмжээ 1.5.12. Монголын уламжлалт спорт, наадам, наадгайг (бөх, сурын харваа, шагайн харваа гэх мэт) хөгжүүлэх, үндэсний баг, тамирчдаа дэмжих, морин болон тэмээн спортын (морин поло, тэмээн поло) төв байгуулж, үндэсний багтай болох, гадаад, дотоодын баг, тамирчдыг урьж тоглуулах тогтолцоог хөгжүүлж, спортын зарим төрлийг олон улсын болон олимпын төрөлд оруулах, түүгээр дамжуулан өөрийн орны соёлыг түгээн дэлгэрүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ. | 3.000.000 | 1.Сургалт, арга хэмжээний тоо<br>2.Оролцсон иргэдийн тоо | 2024 | Сургалт 1<br>Арга хэмжээ 17<br>Оролцогчид 1200 | | Үндэсний спортын төрлөөр аймгийн хэмжээнд өсвөр болон насанд хүрэгчдийн ангилалд нийт 60 удаагийн арга хэмжээ зохион байгуулагдаж 7393 иргэн хамрагдсан. Үүнээс :<br>Үндэсний бөх өсвөр үе 15 удаагийн арга хэмжээнд 3147, насанд хүрэгчид, залуучуудын ангилалд 30 арга хэмжээнд 2294, үндэсний сурын харваа 8 арга хэмжээнд 978, шагайн харвааны төрөлд 7 удаагийн арга хэмжээнд 974 тус тус хамрагдсан байна. | 100% |
| ЗОРИЛГО 3. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА | | | | | | | | |
| 2 | Зорилт 3.5. Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ. | | | | | | | |
| 2.1 | Арга хэмжээ 3.5.1. Биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгох, иргэн, гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн идэвхтэй амьдралын дадал хэвшил төлөвшүүлэх насан туршийн боловсролын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | улсын төсөв | зохион байгуулсан арга хэмжээ | 2024 | 3 арга хэмжээ 4560 | | Иргэдийн эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих зорилтын хүрээнд Өглөөний алхалт, гүйлт 4250 иргэн, Ажлын байрны Түмэн дасгал 6000 иргэн, Монголын шугаман бүжгийн холбоотой хамтран ШУГАМАН БҮЖИГ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДАСГАЛ ХӨДӨЛГӨӨН"-ий сургалтыг Насан туршийн суралцахуйн төвд зохион байгуулж байна. Энэхүү сургалтад 50 гаруй иргэд хамрагдаж өглөөний дасгал хийж байна. Нийт 4 удаагийн сургалтад 195 иргэн хамрагдсан. Баруунтуруун, Хяргас сумдад Шугаман бүжгийн сургалт зохион байгуулж, 250 гаруй иргэд тогтмол хамрагдаж байна. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2 | Арга хэмжээ 3.5.2. Улсын хэмжээнд иргэдийн спортын төрөлжсөн наадмыг 4 жил тутамд зохион байгуулна. | улсын төсөв | Хүүхдийн спортын өвөл, зуны VIII наадмын шигшээ тэмцээнд өвөл, зуны наадмыг зохион байгуулсан байх. | 2024 | оролцоог хангасан байдал | 1000 гаруй иргэнийг хамруулах | Монголын Хүүхдийн спортын 8 дугаар наадмын өвлийн төрөлд гүйлтийн цаны төрлийг аймгийн хэмжээнд амжилттай зохион байгуулж, шигшээ тэмцээнд 3 дасгалжуулагч 14 тамирчин оролцож 3 алт, 5 мөнгө, 7 хүрэл медаль хүртэж цаны төрөлд багаараа Алтан медаль, нэгдсэн дүнгээр 6 дугаар байр, Монголын Хүүхдийн спортын зуны 8 дугаар наадамд спортын 15 төрөлд 145 тамирчин оролцож 4 мөнгө, 7 хүрэл медаль, бүх ард түмний спортын 16 дугаар наадамд 106 тамирчин оролцож 1 алт, 5 мөнгө, 7 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 14 дүгээр байрт тус тус шалгарсан. Аймгийн хэмжээнд хүүхдийн спортын наадмыг өвлийн 1, зуны 15 төрөлд зохион байгуулж 3100 гаруй тамирчид, бүх ард түмний наадмын анхан шатны арга хэмжээнд спортын 8 төрлөөр 1200 гаруй иргэд хамрагдсан. | 100% |
| 2.3 | Арга хэмжээ 3.5.3. Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд, заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлнэ. | төсөв шаардахгүй | Сорилд хамрагдсан ABC үнэлгээтэй иргэдийн эзлэх хувь | 2024 | 2962 буюу 82,4 хувь | | Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, нэгтгэх, цахим программд оруулах ажил хийгдэж байна. Аймгийн хэмжээнд 4500 гаруй иргэдийг сорилд хамруулсан. Одоогоор цахим программд 2800 иргэний мэдээлэл шивэгдэж орсон байна. | 100% |
| | Арга хэмжээ 3.5.4. Хүн амын идэвхтэй | | Сургалтад хамрагдсан | | 2024 онд 7 | | Аймгийн БГ-тай хамтран ЕБС, СӨБ-ийн биеийн тамирын багш нарт 2 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 75 багш ,Соёл, спортын ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам-"ын талаарх сургалтад 20 багш дасгалжуулагч, САУЭШТ, АУА, ЭШССА-ийн эмч мэргэжилтнүүд ЕБС-ийн биеийн тамирын багш, дасгалжуулагчдад Өсвөр насны хүүхдийн физиологийн онцлог, өсвөрийн тамирчдын бэлтгэл дасгалжуулалт төлөвлөлт, бэлтгэл дасгалжуулалтын төлөвлөлтөд анализ хийх, хэт ачааллын шалтгаан, гэмтлийн дараах яаралтай авах арга хэмжээ, гэмтлийн үед болон урьдчилан сэргийлэх зорилгоор тейп боолт хийх, Спортын хоол зүй, Спортын сэтгэл зүй сургалтад 20 багш, дасгалжуулагч, Оюуны бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах арга зүй, тусгай | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4 | амьдралын хэв маягийг дэмжих, идэвхтэй амьдралын аж төрөх ёсны хэрэглээг дэмжсэн судалгаа, сургалт, сурталчилгааг нэмэгдүүлнэ. | 0 | иргэдийн тоо зохион байгуулсан арга хэмжээ | 2024 | удаагийн сургалт мэдээллээр 1100 иргэнийг хамруулах | | олимпын чиглэлээр эмч мэргэжилтэн, багш, эцэг хамгаалагч, мэргэжилтнүүдэд зориулсан сургалтад 130 хүн тус тус хамрагдлаа. Нийт 5 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 245 хүнийг хамрууллаа. Аймгийн ЗД-ын дэргэдэх агентлагууд болон төрийн байгууллагын дарга эрхлэгч 60 гаруй удирдах албан тушаалтанд Алхалт болон, ажлын байрны Түмэн дасгал-ын сургалт, Улаан Уул, Гашууны голын чиглэлд алхалт хийж буй иргэдийг олон нийтэд сурталчлах, 10000 алхалтыг хэмжигч "STRAVA" апп хэрхэн ашиглах талаар сургалтыг зохион байгуулав. Мөн Монголын шугаман бүжгийн холбоо, Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран ЭРҮҮЛ МЭНДИЙН ДАСГАЛ,ШУГАМАН БҮЖИГ"-ийн сургалтыг зохион байгуулж 50 гаруй иргэд хамрагдлаа. Мөн Баруунтуруун сумын соёлын төвтэй хамтран Шугаман бүжгийн сургалт зохион байгуулж, 150 гаруй албан хаагчид хамрагдлаа. | 100% |
| 2.5 | Арга хэмжээ 3.5.5. Олон улсын шаардлага, стандартад нийцсэн орчинд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | улсын төсөв | гүйцэтгэлийн хувь | 2024 | | 49.0 сая төгрөг | Спортын ордоны их засварын ажлын тооцоог Өлзий Иш ХХК-аар гүйцэтгүүлэхээр санал хүргүүлж, төсвийг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна. Байгууллагын болон албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах зорилгоор байгууллагын дотно болон гадна талд тохижилт, засвар үйлчилгээ хийх,зүлэгжүүлэлт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг зохион байгуулж, сургалтын танхим болон үүдний хэсэгт тохижилт хийгдлээ. Спортын ордоны шал будах, сургалтын танхим тохижуулах, албан хаагчдын болон ОО-ын өрөөний хаалга, хана шинэчлэх, гадна тохижилт, зүлэгжүүлэлт, цэцэгжүүлэлтэд нийт 19,0 сая төгрөг, бөхийн Шандас клубын халаалт, спортын ордоны халаалт, шугам засварын ажилд орон нутгийн төсвөөс 30,0 сая төгрөг нийт 49,0 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.7 | Арга хэмжээ 3.5.7. Биеийн тамир, спортын санхүүжилтийг боловсронгуй болгож, хувь хүний хэрэгцээг хангасан байдал, чанартай үйлчилгээ, гарц болон гүйцэтгэлд тулгуурлан санхүүжүүлнэ. | 0 | Хамтран ажилласан спортын холбоодын тоо | 2024 | 2024 онд 89.2 сая | 22 спортын холбоонд 85.0 сая төгрөг | Спорт, биеийн тамирын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй спортын 22 холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулж, 89,8 сая төгрөгийн үйл ажиллагаа, уралдаан тэмцээнийг санхүүжүүлсэн байна. | 100% |
| 2.8 | Арга хэмжээ 3.5.8 Биеийн тамир, спортын салбарын мэдээллийн технологийн удирдлага, зохион байгуулалт үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн нэгдсэн бааз, платформ бий болгоно. | төсөв шаардахгүй | Цахим бүрдүүлэлтийн тоо | 2024 | Цахим бүрдүүлэлтийн тоо | | Байгууллагын пейж хуудсанд нийт 411 (цаг үеийн нөхцөл байдал, нийтийг хамарсан арга хэмжээний тухай 88,уралдаан тэмцээний талаархи 174, бэлтгэл, сургуулилтын мэдээлэл 7, постер мэдээлэл 48, видео бичлэг 19, шейр хийсэн 75) мэдээлэлийг оруулж нийт 2.166.498 хүнд хүргэж ажилласан. | 100% |
| 2.1 | Арга хэмжээ 3.5.10. Биеийн тамир, спортын үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, шилжилт хөдөлгөөн, тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна. | | арга хэмжээний тоо | 2024 | | | Монголын чөлөөт бөхийн холбоотой хамтран Чөлөөт бөхийн U17, U23 насны улсын аварга шалгаруулах тэмцээнийг орон нутагтаа амжилттай зохион байгуулж 32 багийн 850 гаруй тамирчид, багш дасгалжуулагчид оролцож , аймгийн хэмжээнд худалдаа үйлчилгээ эрхэлж буй иргэд болон аж ахуйн нэгжүүдэд 150,0 гаруй сая төгрөгийн худалдан авалт хийгдсэн байна.<br>Улсын аварга шалгаруулах тэмцээн спортын 3 төрөлд, баруун бүсийн тэмцээн 2-ийг аймгийн төвд сумдад 3 удаагийн тэмцээнийг зохион байгуулсан. | 100% |
| 2.12 | Арга хэмжээ 3.5.12. Хүүхэд, залуучуудын авьяасыг нээх, шилдэг тамирчдыг бэлтгэх, хөгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно. | 0 | Зохион байгуулсан уралдаан тэмцээн | 2024 | Оролцсон тамирчдын тоо, медиалын тоо | | Биеийн тамир, спортыг дэмжих хөтөлбөр боловсруулж, аймгийн ЗД-ын зөвлөлөөр 2 удаагийн хэлэлцүүлэг хийж аймгийн ИТХ-д оруулж батлуулахад бэлэн болсон.<br>Хөтөлбөрийн хүрээнд чөлөөт бөхийн U-17, U-23 ангилалын Улсын аварга шалгаруулах тэмцээнийг Увс аймагт анх удаа зохион байгуулж, спортын хөгжлийг дэмжих төсөл арга хэмжээний зардлаас 32.280,0 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>УАШТ-д 43 багийн 850 гаруй тамирчид, дасгалжуулагчид оролцож Увс аймаг U-23 ангилалд 36, U-17 ангилалд 47 тамирчид оролцож Алтан медаль -4, Мөнгөн медаль-6, Хүрэл медаль-10, нийт 20 медаль хүртсэн байна.<br>U-23 ангилалд эрэгтэй багийн дүнгээр 2 дугаар байр, эмэгтэй багийн дүнгээр 3 дугаар байранд шалгарсан.<br>Аймгийн хэмжээнд спортын 15 төрлөөр УАШТ-д оролцож 137 медаль, Олон улс болон тивийн АШТ-с 5 медаль, ДАШТ-с 3 медаль хүртсэн байна.<br>Нийт 13 арга хэмжээнд 209.0 сая төгрөгийн санхүүжилт, мөнгөн дэмжлэг үзүүлсэн байна. | 100% |

**“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**
**УВС АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР**
**2025 ОНЫ ЖИЛ ЭЦЭС**

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төсөв | | | | | | |

| № | Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг | /2023 | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | | Хүрсэн түвшин | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Он | Түвшин | Зорилтот түвшин | | |
| **“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН** | | | | | | | | |
| 1 | Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт (насны ангиллаар) | 0 | Сорилд хамрагдсан<br>А, В, С үнэлгээтэй хүний тоог сорилд хамрагдсан хүний тоонд харьцуулж 100-гаар үржүүлнэ. | 2024 | 2495 | 2520 | Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, нэгтгэх, цахим программд оруулах ажил хийгдэж байна. Аймгийн хэмжээнд 4500 гаруй иргэдийг сорилд хамруулсан. Одоогоор цахим программд 2800 иргэний мэдээлэл шивэгдэж орсон байгаа бөгөөд АВС үнэлгээтэй иргэд 1249 буюу 49.5 хувь | 50% |

Тайлайг хянасан БТСГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Бадарч

Биелэлт гаргасан: БТХ-ийн дарга Х.Баяртуул

9065334 1524050002

**МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ**
**УВС АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР**
**2025 ОН**

2025 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр

| № | Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг | Төсөв<br>Сая.төг | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин<br>2022 он | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар) | 2021-2025 оны хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА | | | | | | | |
| 3.5. Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ | | | | | | | |
| 1 | 3.5.1. Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | 2021 - 2025 | 23 спортын холбоонд 89 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 58 медаль хүртсэн. | 20 холбоонд 85.сая төгрөг | 2025 онд спорт, нийтийн биеийн тамирын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Спортын 22 холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулж, 89.6 сая төгрөгийн санхүүжилтыг олгосон байна. 2025 онд УАШТ-3, баруун бүсийн -2, аймаг, сумын 36 арга хэмжээг зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд 155 уралдаан тэмцээнд нийт 39341 гаруй, нийтийн биеийн тамирын 88 арга хэмжээнд 25384 иргэн нийт 68250 иргэн хамрагдсан байна. | Олон улсын хэмжээний "Их Алтай-2023", "Энхийн гүйлт", улсын хэмжээний "Нэг аймаг 100 км" явган алхалт, "Үндэсний цом-2022" хөл бөмбөгийн аварга, чөлөөт бөх, даамын улсын аварга шалгаруулах тэмцээн, Жүдо, байт харвааны баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээн "Хонхот бөмбөг" улсын аварга, "Оюутны спорт, урлагийн их наадам", "Хүүхдийн спортын 7,8-р их наадам", "Аваргуудын нэрэмжит үндэсний бөхийн барилдаан", "Нөхөрлөл" сурагчдын волейболын лиг зэрэг томоохон уралдаан, тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулж, дэмжиж ажиллаа.2021-2024 онд Увс аймгийн баг, тамирчид тив, дэлхий болон улсын аварга шалгаруулах тэмцээнд 20 гаруй төрлөөр оролцож, 425 медаль хүртлээ. Амжилт гаргасан тамирчин, багш, дасгалжуулагч нарт 365,9 сая төгрөгийн дэмжлэг, урамшуулал олголоо. |
| 2 | 3.5.2. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмж нэмэгдэнэ. | Орон нутгийн төсөв 249,0 сая төгрөг, Хандив 50,0 сая төгрөг | спортын барилга, байгууламжид засвар үйлчилгээ, тохижилт хийсэн то | | | Спортын ордоны их засварын ажлын тооцоог Өлзий Иш ХХК-аар гүйцэтгүүлэхээр санал хүргүүлж, төсвийг шинэчлэн боловсруулах ажил хийгдэж байна.Байгууллагын болон албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах зорилгоор байгууллагын дотно болон гадна талд тохижилт, засвар үйлчилгээ хийх, зүлэг, цэцэг тарих ажлыг зохион байгуулж, сургалтын танхим болон үүдний хэсэгт тохижилт хийгдсэн. Мөн Спортын ордоны шал будах, сургалтын танхим тохижуулах, албан хаагчдын өрөө, ОО-ын өрөөний шал, ханыг шинэчлэн 19,0 сая төгрөг, бөхийн Шандас клубын болон спортын ордоны халаалт, шугам засварын ажлыг албан хаагчдын нөөц боломжоор хийж орон нутгийн төсвөөс 30,0 сая төгрөг, нийт 49 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна. Малчин сум 100 жилийн ойн хүрээнд 3х3 сагсан бөмбөгийн талбай /10х16 хэмжээтэй/ 50,0 сая төгрөгөөр хандиваар, 5х5 сагсан бөмбөгийн 28х16 хэмжээтэй талбайг орон нутгийн төсвийн 49,5 сая төгрөгөөр, Түргэн сумын орон нутгийн төсвийн 200.0 сая төгрөгөөр хөл бөмбөг, нийтийн биеийн тамирын зориулалттай талбай байгуулсан. | 2021-2025 онд улс, хувийн хэвшлийн төсвөөр Зүүнговь, Тариалан, Хяргас, Малчин, Өмнөговь, Улаангом сумдад спорт заал, Улаангом сумын 1, 2, 4, 5, 6 дугаар сургуульд нийтийн биеийн тамирын талбайг шинээр байгуулсан. Мөн наадмын талбайн 6 удаагийн тохижилтыг хийж орчин нөхцлийг сайжруулж ажилласан. Үр дүн: Сумдад 6 спорт заал шинээр баригдаж, стандартын шаардлага хангасан 11 спорт заалтай боллоо. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | 3.5.3. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлнэ. | Улсын төсөв - 13,0 сая төгрөгОрон нутгийн төсөв ХБИ-ийг дэмжих зардлаас 5,0 сая төгрөг | Нийтийн биеийн тамирыг дэмжсэн арга хэмжээ зохион байгуулсан тоо, сорилд хамрагдсан иргэдийн то | 38 удаагийн арга хэмжээнд 7794 иргэн хамрагдсан | 1. 40 2. 21465 | Иргэдийн биеийн тамираар хичээл, эрүүл амьдралын хэв маягийг дэмжих зорилтын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаа.<br>Аймгийн ЭМГ-тай хамтран "Эрүүл мэндийнхээ төлөө алхахад цаг гаргая" арга хэмжээг 2 сарын хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулж, 12 сумын давхардсан тоогоор 4250 иргэн алхалтад хамрагдлаа. Мөн албан хаагчдын ажлын байрны дасгалыг хэвшүүлэх зорилгоор "Түмэн дасгал" арга хэмжээг 2 сарын хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулж, 75 байгууллагын 6000 гаруй иргэд дасгалд хамрагдлаа. Аяны үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон байгууллага, хамт олныг шалгаруулж 7035,0 сая төгрөгөөр урамшууллаа. Арга хэмжээг иргэдийн нас, биеийн онцлогт тулгуурлан зохион байгуулж байна. Нийт 2 аян, 88 арга хэмжээ, сургалт мэдээллийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 25384 иргэн хамрагдсан байна. | Илүүдэл жингүй эртэч Монгол", "Эрүүл мэндийн цахим гүйлт", "Дасгал хөдөлгөөнөөр хичээллэцгээе", "Цахим гимнастрада", "Увсын цэнхэр хязгаар-Хяргас нуур" зэрэг томоохон аян, арга хэмжээг зохион байгуулж, 40-50 мянган иргэнийг спорт, нийтийн биеийн тамирын арга хэмжээнд жил бүр хамруулан ажилласан. Үр дүн:<br>Биеийн тамир, спортын арга хэмжээнд жилд 40-50 мянган иргэн хамрагдаж, суурь түвшнээс 4-5 дахин өслөө.<br>Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагчдаас A, B, C үнэлгээтэй иргэдийн тоо 2021 онд 33.7 хувь байсан бол 2024 онд 71 хувь болж 2 дахин өссөн. |

Тайланг хянасан БТСГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Бадарч

Биелэлт гаргасан: БТХ-ийн дарга Х.Баяртуул

9065334 1524050002

# УВС АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2025.12.10

**Нэг.** Хяналт- шинжилгээ үнэлгээний зорилго

Биеийн тамир спортын газрын 2025 оны хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланд хяналт -шинжилгээ үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж боловсруулан удирдлагыг үнэн бодит мэдээлэлээр хангах, дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

**Хоёр** Хяналт- шинжилгээ үнэлгээний үндэслэл,үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Хяналт шинжилгээ,үнэлгээ хийх журам”-ыг 2 дугаар хавсралт “Үнэлгээ хийх журам”-ыг 3 дугаар хавсралт “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг тус тус удирдлага болгов.

БТСГазар нь 2025 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Зарлиг- 1, МУЗГ-ын тогтоол- 1, МУЗГ-ын хуралдааны тэмдэглэл-1,ЗГ-ын албан даалгавар-1 тус бүр хяналтанд авч хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

**Гурав.** Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний үр дүнгийн талаар

***Монгол Улсын Ерөнхийлөгчийн Зарлиг 3/26/2010 “Нийтийн биеийн тамир,спортыг хөгжүүлэх тухай” 53 дугаар зарлигийн хэрэгжилтийн үр дүн:***

БТСГазар 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд МУЕрөнхийлөгчийн 53 дугаар зарлигтай уялдуулан 4 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд хэрэгжилийг 75% хангасан байна.

“Хүн амын бие бялдрын хөгжил чийр эгжилтийн түвшин тогтоох сорил”-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, сорилын үр дүнг цахимд системд оруулах үнэлгээг насны ангилалаар гаргаж жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг, 50% -иар биелүүлсэн байна.

Биеийн тамир спортыг нийтийн үйл хэрэг болгох зорилтын хүрээнд аймгийн хэмжээнд спортын 9 төрлөөр 38 клуб секцид 4800 гаруй өсвөр залуучууд хамрагдаж ЕБ сургуулиудын сурагчдын дунд 2 арга хэмжээг тогтмол зохион байгуулж хэвшсэн нь өсвөр үе залуучуудыг сонирхсон спортын төрлөө сонгон хичээллэх нөхцөл боломжийг хангаж хэрэгжилтийг 97 хувиар биелүүлсэн байна.

***МУЗасгийн газрын 08/30/2023 "Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай" 321 дүгээр тогтоолын хэрэгжилтийн үр дүн:***

БТСГазар 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ЗГ-ын 321 дүгээр тогтоолтой уялдуулан 3 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд хэрэгжилийг 100% хангасан байна.

Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээнд 2 аян 88 арга хэмжээ зохион байгуулж 25384 иргэнийг хамруулж иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэнддээ анхаархад нь дэмжлэг үзүүлж ажилласан байна.

***Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 54 дэх тэмдэглэлийн- III.2 11/09/2022 хэрэгжилтийн үр дүн:***

БТСГазар 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ЗГ-ын 54 дэх тэмдэглэлийн III.2-тай уялдуулан 1 арга хэмжээ, хэлтсийн төлөвлөгөөнд 3 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 1 арга хэмжээ 100% хэрэгжиж хэлтсийн төлөвлөгөөнд туссан 3 арга хэмжээ санхүүжилтгүйн улмаас хэрэгжилт хангагдаагүй байна.

***Монгол Улсын Засгийн газрын албан даалгавар 2024.01.01 хэрэгжилтийн үр дүн:***

БТСГазар 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ЗГ-ын албан даалгавартай уялдуулан 12 арга хэмжээг

- ✓ Өвлийн биеийн тамирын арга хэмжээ
- ✓ Өсвөр үеийнхэний биеийн тамир
- ✓ Ахмадын биеийн тамир
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн биеийн тамир
- ✓ Үндэсний спортыг сурталчлах арга хэмжээ
- ✓ Сумдын биеийн тамирын арга хэмжээ
- ✓ Сургалт сурталчилгаа, мэдээлэл хүргэх гэсэн ангилалаар 2 аян 88 арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж 25384 иргэнийг хамруулж хэрэгжилтийг 100% хангасан байна.

**Дөрөв. Дүгнэлт**

БТСГ-ын 2025 онд хяналтад авч хэрэгжүүлсэн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 93,7% буюу арга хэмжээнүүдийг оновчтой тодорхойлж зохион байгуулсан, зорилтот түвшиндээ хүрч үр дүн гарч эхэлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 54 дэх тэмдэглэлийн- III.2 11/09/2022 уялдуулан 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 1 арга хэмжээ, хэлтсийн төлөвлөгөөнд тусгасан 3 арга хэмжээ санхүүжилт татагдсан учраас зохион байгуулагдаагүй учраас үнэлгээнд оруулаагүй болно.

**Тав.Зөвлөмж**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилттэй уялдуулж төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдлийг урьдчилан тооцоолох.

Аймгийн хэмжээнд зохион байгуулсан сорилын арга хэмжээний хэрэгжилтийг хангаж цахим системд иргэдийн мэдээлэлийг бүрэн оруулж тайлагналтын хувийг ахиулах шаардлагатай байгааг тус тус зөвлөмжилж байна.

ХЯНАСАН:
УВС АЙМГИЙН БТСГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАДАРЧ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,ДОТООД АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Т.ӨЛЗИЙХИШИГ